



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 01-р сарын 16-ны өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ТУХАЙ

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, 12 дугаар бүлэг, “Сүү” ХК-ийн 2025 оны 01 сарын 16-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад заасан “Макс Импэкс” ХХК-ийн нэгдэлд багтах компаниудтай сонирхлын зөрчилтэй хэлцэл, гэрээнүүдийг 3,000,000,000 /Гурван тэрбум/ төгрөг хүртэл үнийн дүн бүхий Худалдах худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, барьцааны гэрээ, зээлийн гэрээ, эд хөрөнгө хөлслөх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ, тээвэрлэлтийн гэрээнүүдийг 2026 оны 01 сарын 16-ны өдрөөс 2027 оны 01 сарын 16-ны өдөр хүртэл 1 жилийн хугацаагаар холбогдох дүрэм, журам, хөдөлмөрийн гэрээний хүрээнд тус тус байгуулахыг “Сүү” Хувьцаат Компанид зөвшөөрсүгэй.
2. Энэхүү тогтоолтой холбогдуулан Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 05 дугаар тогтоолыг 2026 оны 01 сарын 16-ны өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.
3. Хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд сонирхлын зөрчилтэй хэлцэл, гэрээ байгуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Гантулга/-д зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Д.ГАНБААТАР